



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/266.

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн сайдын 2008 оны “Менингококкт халдвартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” 37 дугаар тушаал, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захиралын хамтарсан 2018 оны А/30,А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Менингококкт халдварын үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах нь” сэдэвт сургалтыг дүүргийн хэмжээнд чанарын өндөр түвшинд зохион байгуулсугай.

2. “Менингококкт халдварын үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах нь” сургалтыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтыг үр дүнтэй, чанартай зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч, Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Т.Гэрэлсүрэн/-д үүрэг болгосугай.

4. Сургалтанд эрүүл мэндийн төвийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, Өрхийн менежер, Чанарын менежер, Сувилахуйн албаны дарга, Хүүхдийн ерөнхий зохицуулагч, Өсвөр үеийн эмч, Халдвар судлаач, Хэвтэн эмчлүүлэх тасаг, Поликлиник, Салбар амбулатори, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарыг хамруулахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Гэрэлсүрэн/-д даалгасугай.

5. Төсвийг холбогдох санхүүжилтээс гаргахыг Ерөнхий нягтлан /Д.Хишигсүрэн/-д зөвшөөрсүгэй.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын албаны дарга /Э.Оюумаа/-д даалгасугай.


ДАРГА

Э.БОДЬЦЭЦЭГ



3 170 70 0203

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2018 оны 03 дугаар сарын 14 -ны өдрийн
4/26 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч Т.Гэрэлсүрэн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

Нарийн бичиг Д.Ичинхорлоо Тархвар судлаач

Гишүүд П.Төгсжаргал Халдвартын их эмч

С.Өлзийжаргал Халдварт өвчин тандалт судалгаа
эрүүл ахуйн тасагийн эрхлэгч

Ө.Ариунжаргал Халдвар судлаач


Г.Даваасүрэн Өрхийн менежер

Б.Халиунгэрэл Сувилахуйн албаны дарга

П.Тогтох-Эрдэнэ Хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч

Ц.Оюунчимэг Чанарын менежер

:



**“МЕНИНГОКОККТ ХАЛДВАРЫН ҮЕИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ
САЙЖРУУЛАХ НЬ” СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

НЭГ. Зорилго:

Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг эмнэлгийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд амьсгалын замын цочмог халдвар болон Менингококкт халдвараас урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлэх, голомтын хариу арга хэмжээ авах чадварыг сайжруулахад оршино.

ХОЁР. Хамрах хүрээ:

Эрүүл мэндийн төвийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, Өрхийн менежер, Чанарын менежер, Сувилахуйн албаны дарга, Хүүхдийн ерөнхий зохицуулагч, Өсвөр үеийн эмч, Халдвар судлаач, Хэвтэн эмчлүүлэх тасаг, Поликлиник, Салбар амбулатори, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувиалгч нар

ГУРАВ. Хаана.

Эрүүл мэндийн төвийн сургалтын өрөөнд

ДӨРӨВ. Хугацаа:

2018 оны 03 дугаар сарын 16-ний өдрийн 09.00 цагт

**ТАВ. “Менингококкт халдварын үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах нь
сургалтын хөтөлбөр**

№	Хичээлийн сэдэв	Хариуцах эзэн
1	Бүртгэл, нээлт	ХӨСҮТ-ийн Н.Энхцэцэг НЭМГ-ын мэргэжилтэн Э.Навчаа
2	Менингококкт халдварын эмнэлзүй, оношилгоо, эмчилгээ	ХӨСҮТ-ийн СЭЭТ-ийн их эмч М.Ууганчимэг НЭМГ-ын мэргэжилтэн Э.Навчаа
3	Тархварзүйн тандалт, голомтод авах арга хэмжээ	ХӨТСА-ны Тархвар судлаач их эмч Ч.Уртнасан, Д.Оюунгэрэл НЭМГ-ын мэргэжилтэн Э.Навчаа
4	Менингококкт халдварын үед нян судлалын шинжилгээнд сорьц цуглуулах, тээвэрлэх, шинжлэх	ХӨСҮТ-ийн Нян судлалын лабораторийн эрхлэгч Т.Одгэрэл НЭМГ-ын мэргэжилтэн Э.Навчаа
	Хаалт, ярилцлага	Оролцогсод

ЗУРГАА. Хүрэх үр дүн:

Эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн сэхээн амьдруулах яаралтай тусламжийн тасгийн эмч, өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ залуу эмч нарт Менингококкт халдварын үеийн оношилгоо, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах, эмч нарын оношилгоо, эмчилгээний чадварыг сайжруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний алдаа, зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх мэдлэгтэй болсон байна.



Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2018 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн
41/26 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

СУРГАЛТЫН ЗАРДАЛ

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Дэвтэр	60	1800	108.000
2	Бал	60	250	15.000
3	Нийт			123.000